

9

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ГАДААД ЯВДЛЫН ЯАМНЫ ДҮРЭМ

Нэгдүгээр бүлэг.ЕРӨНХИЙ ЗҮЙЛҮҮД

1.Гадаад явдлын яам бол үндсэн хуулийн ёсоор ба тус улсын олон яамдын тухай ерөнхий дүрэмд нийлүүлэн ажлаа зохиож явуулна.

2.Гадаад явдлын яам бол БНМАУ-аас бусад улсуудтай харилцах дипломатын харилцааг биелүүлэн гүйцэтгэх бөгөөд Ардын Сайд нарын Зөвлөлд шууд харъяалагдан захирагдах ба түүний тогтоол,заавар, бодлогуудыг еерийн ажил дээрээ ёсчлон биелүүлэн гүйцэтгэнэ.

3.Гадаад явдлыг яамыг Гадаад явдлын яамны сайдаас тэргүүлэн удирдах бөгөөд мөнхүү сайдын туслахад ардын Сайд нарын Зөвлөлөөс орлогч сайдыг томилно.

4.Гадаад явдлын яамны сайд ба орлогч сайдын эрх үүрэг хариуцлагыг олон яамдын тухай ерөнхий дүрэмд тодорхойлогдох болно.

Хоёрдугаар бүлэг.ГАДААД ЯВДЛЫН ЯАМНЫ  
ЗОРИЛГО,БОДЛОГЫН ТУХАЙ

1.Тус улсын гадаадын улс төрийн ба эдийн засаг,аж ахуйн ашиг тусын явц ба мөн хилийн цаана гадаад улсад сууж буй тус улсын харъяат нарын ашиг тус зэргийг хамгаална.

✓ 2.Ардын сайд нарын Зөвлөлөөс даалгасан ёсоор гадаад улсуудтай гэрээ найрамдлыг байгуулна.

3.Гадаад улстай байгуулсан гэрээ,найрамдал зэргийг зохих засаг захиргааны ба албан газруудаас гүйцэтгэх явдлыг удирдах ба хэрхэн ёсчлон гүйцэтгэж буйг хянан харгалзана.

Гуравдугаар бүлэг.

ГАДААД ЯВДЛЫН ЯАМНААС ЭРХЛЭХ ХЭРГҮҮД НЬ:

1.Тус улсаас хилийн цаана суух дипломатын ба консулын газрыг удирдан зааварлана.

2.Тус улсын дотор сууж буй гадаад улсын дипломатын ба консулын газартай харилцах.

3.Ардын Сайд нарын Зөвлөлөөс даалгасан буюу зөвшөөрсөнөөр гадаад улсуудтай байгуулах элдэв зүйлийн гэрээ хэлэлцээ зэргийг зохих холбогдох газруудтай хамтарч бэлтгэх.

4.Гадаад улсуудтай байгуулсан гэрээ найрамдлуудыг аливаа газруудаас хэрхэн гүйцэтгэж буйг хянах ба ийнхүү хянасан тухайг Сайд нарын Зөвлөлд илтгэн мэдүүлж байх.

5.Гадаад улсуудын улс төрийн ба эдийн засгийн явдал ямар болж байгаа ба мөн харъяат яам ба тус яамны харъяалагдах газруудаас явуулсан ажлын тайлан илтгэл,мэдээг зохиох.

6. Тус улсын улс төрийн ба соёл боловсрол эдийн засаг үйлдвэрлэх хүчний зэрэг явдал ямар болж байгаа тухайг тус улсаас гадаадад сууж буй дипломатын газруудад тухай бүр мэдэгдэж байх.

7. Тус улсын харъяат газруудаас гадаадын газруудтай хэрхэн харилцах журмыг тогтоох.

8. Тус улсын дотор сууж буй гадаадын дипломатын ба консулын газруудыг хамгаалах явдлыг зохион байгуулах;

9. Гадаадад сууж буй тус улсын харъяат нарын эрх ашгийг нь дагаж шийтгүүлэн буй дүрэм хэмжээний ёсоор сахиж хамгаалах ба мөн тэд нарыг бүртгэх.

10. Тус улсад сууж буй гадаадын харъяат нарын эрх үүргийг дагаж шийтгүүлэн буй хууль дүрмийг баримтлан тогтоох.

11. Орон нутгийн захиргааны газруудаар уламжлан тус улсад сууж буй гадаадын харъяат нарыг бүртгэн мэдэж байх.

12. Гадаадын сонин сэтгүүлийн газруудтай харилцах

13. Дипломатын шууданг эрхлэх

14. Гадаадад явах дипломатын паспорт бичгийг олгох.

15. Тус улсын дотор сууж буй дипломатын хүмүүст албаны үнэмлэх олгох ба виз дарах.

16. Тус улсаас гадаадад сууж буй дипломатын газруудад өөрийн улсаас гаргаж буй хэвлэлүүдээр хангах.

Дөрөвдүгээр бүлэг

Тус яамны дотоод зохион байгуулалт нь:

1. Өрнөт хэлтэс

2. Дорнод хэлтэс гэж 2 хэлтэстэй байна

3. Тус улсаас гадаадад суух дипломатын ба консулын газрууд нь харьяалагдан захирагдана.

Тавдугаар бүлэг

Гадаад явдлын яамны төлөөлөгчдийн тухай

1. Зарим аймгуудын төвд Сайд нарын Зөвлөлөөс гадаад явдлын яамны төлөөлөгчдийг аймгийн яамны гишүүдийн дотроос хавсруулан томилж суулгана.

2. Гадаад явдлын яамны төлөөлөгчид бол уул үүргээ харъяат яамны заавраар гүйцэтгэнэ.

3. Мөнхүү төлөөлөгчийн гүйцэтгэсэн ажлын идтгэл мэдээг авч хариу зааврыг өгч байна.

Зургадугаар бүлэг

3.

Гадаадад суух тус улсын бүрэн эрхтэй элчин төлөөлөгчдийн яамд ба консулын тухай.

I. Тус улсаас гадаадад суух бүрэн эрхтэй элчин төлөөлөгчид ба консулууд бол тусгай дүрмийн ёсоор ажлаа явуулна.

{ Энэхүү дүрмийг 31 он 9-р сарын 19-ний өдрийн Ардын Сайд нарын Зөвлөлийн 48 дугаар хурлын II-р зүйлд батлагдав.

*Улсын архивтай.*

*(1931 оны 9р сарын 19-ний өдөр  
Ардын Сайд нарын  
Зөвлөлийн ~~3р зүйлд~~ <sup>мөртөө</sup>)*